

СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ



Д.УРАНТОГОС

**ХАЛХГОЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
11-Р АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

**А хувилбар**

*Асуулт даалгавар бүрийг анхааралтай уншиж, зөв хариултыг хариултын хуудсанд тэмдэглэнэ үү.*

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ /60 оноотой/**

1. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /2 оноо/  
..... гэдэг нь тодорхой хэв шинжит харилцаа бүхий тэгш бус байдлын тогтолцоо.  
A. Тэгш бус байдал  
B. Нийгмийн давхраажилт  
C. Нийгмийн давхраа  
D. Нийгмийн нийтлэг  
E. Нийгмийн ялгарал
2. Соёлын аялал жуулчлал гэсэн ойлголтыг хэдэн оноос эхлэн хэрэглэсэн бэ? /2 оноо/  
A. 1970 он  
B. 1980 он  
C. 1990 он  
D. 2000 он  
E. 2005
3. Хуулийн дагуу, тогтоогдсон хэмжээгээр бүх хүн, хуулийн этгээдээс төрд заавал төлөх, буцалтгүй шинжтэй хураамжийг юу гэж нэрлэдэг вэ? /2 оноо/  
A. Хураамж  
B. Татвар  
C. Бонд  
D. Татаас  
E. Хувьцаа
4. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /2 оноо/  
..... бол иргэд төрийг хянаж, төрд хариуцлага хүлээлгэж чаддаг хүмүүсийн нэгдэл. Өөрөөр хэлбэл хүмүүс хамтран нэгдэж, үзэл бодлын хүрээгээрээ өөрсдөө зохион байгуулахыг хэлнэ.  
A. Лобби бүлэг  
B. Улс төрийн нам  
C. Иргэний нийгэм  
D. Сонирхлын бүлэг  
E. Улс төрийн институт
5. Аймаг, нийслэлийн засаг дарга эрх зүйн ямар акт гаргадаг вэ? /2 оноо/  
A. Тушаал  
B. Захирамж  
C. Шийдвэр  
D. Тогтоол  
E. Зарлиг
6. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактыг хэдэн онд баталсан бэ? /2 оноо/  
A. 1948 он  
B. 1966 он  
C. 1996 он  
D. 2000 он  
E. 2002 он
7. Засгийн газрын оролцоо дэмжлэггүйгээр улс, үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулдаг глобал түвшний оролцогчид, тоглогчид, олон улсын байгууллагыг юу гэж нэрлэдэг вэ? /2 оноо/  
A. Олон улсын харилцаа  
B. Улс бус оролцогч  
C. Олон улсын эрх зүй  
D. Гуравдагч хөршийн бодлого  
E. Түншлэлийн харилцаа

8. Олон улсын байгууллагын үйл ажиллагааны глобал түвшинд аль нь хамаарах вэ? /2 оноо/

- A. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн
- B. Ази Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны чуулга
- C. Аль Кайда бүлэглэл
- D. Евразийн эдийн засгийн холбоо
- E. Walmart

9. Дараах ойлголтоос аль нь бурангүй үзлийг тодорхойлсон байна вэ? /2 оноо/

- A. Нэг бүлэгт давуу боломж олгосон атлаа нөгөөгийнх нь боломжийг хаах үйлдэл
- B. Хүний нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийг тодорхойлж байдаг.
- C. Нэг бүлгийнхний зүгээс нөгөө бүлгээ тодорхойлдог үзэл бодол, хандлага
- D. Нийгмийн гишүүд хувийн болон нийгмийн шинжээрэй зааглагдан хуваагдах ойлголт.
- E. Эрэгтэй, эмэгтэй хүний нийгмийн бүтэц, соёлоос хамааран тодорхойлогдох ялгаа.

10. Хувь хүний бүтээлч сэтгэлгээ, ур чадвар, авьяас билгээс эх сурвалжтай, оюуны өмчөөр хамгаалагдсан соёлын агуулга бүхий бараа, бүтээл үйлдвэрлэх, тэдгээрийн хуваарилалт, нийлүүлэлтийн тогтолцоог хангасан үйлдвэрлэлийн салбарыг юу гэж нэрлэдэг вэ? /2 оноо/

- A. Соёлын даяаршил
- C. Соёлын адилсал
- B. Соёлын аялал жуулчлал
- D. Соёлын үйлдвэрлэл
- E. Соёлын нэгдмэл шинж

11. Дараах эрдэмтдийн алиных нь онол макро эдийн засгийн онолын цаашдын хөгжил болон барууны орнуудын төрийн эдийн засгийн бодлогод чухал нөлөө үзүүлсэн бэ? /2 оноо/

- A. А. Смит
- B. Ф. Хайек
- C. М. Кейнс
- D. Д. Рикорда
- E. Р.Дарендорьф

12. Дараах эдийн засгийн ойлголтоос аль нь Ф. Хайекийн үзэл баримтлал вэ? /2 оноо/

- A. Эдийн засаг дахь зах зээлийн тогтолцоо нь уналтаас өөрийгөө аврахгүй.
- B. Эдийн засаг дахь төрийн идэвхтэй оролцоо нь түүнд зөвхөн хор учруулна.
- C. Эдийн засагт төрийн оролцоо нь нийт эрэлтийг нэмэгдүүлэх гол арга зам юм.
- D. Эдийн засаг дахь уналт нь түүний онолыг батлаж, хямралаас гаргасан.
- E. Эдийн засаг дахь мөнгө, банкны онол нь банкны шинэчлэлд чухал үүрэгтэй.

13. Улс төр судлаач Г.Алмондын тодорхойлсон улс төрийн системийн гаралтын чиг үүрэгт хамаарах өгөгдлийг олно уу. /2 оноо/

- A. Хууль зүйн хэм хэмжээ, шийдвэр боловсруулах
- B. Улс төрийн нийгэмшилтийг хангах
- C. Нийгэм дэх бүлгийн сонирхлыг илрүүлэн гаргах
- D. Явцуу олон шаардлагыг нэгтгэн боловсруулах
- E. Нам нь сонгуулиар дамжин төрийн эрх барих

14. Дараах өгөгдлөөс улс төрийн намын зорилгыг ялгаарай. /2 оноо/

1. Иргэдийн улс төрийн хүсэл зорилгыг хэрэгжүүлэх
2. Улс төрчдийг бэлтгэн чадавхжуулж нэр дэвшүүлэх
3. Засгийн эрхийг авахын төлөө өрсөлдөх
4. Намын дотоод ардчиллыг хангах, бэхжүүлэх

A. 1, 3

B. 2, 4

C. 2, 3

D. 1, 2

E. 3, 4

15. Дараах тодорхойлолтоос эрх зүйн зөрчил гэсэн ойлголтыг аль нь илэрхийлж байна вэ? /2 оноо/

- A. Нийгэмд хор аюултай, хууль зүйн хариуцлага хүлээлгэх шаардлагатай, эрүүгийн хуульд заасан гэм буруутай бүх үйлдэл эс үйлдлийг хэлнэ.
- B. Нийгэмд хор аюултай, хууль зүйн хариуцлага хүлээлгэх шаардлагатай, гэм буруутай үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.
- C. Нийгэмд хор аюултай, эрүүгийн хуулиас бусад хууль зөрчсөн гэм буруутай бүх үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.
- D. Нийгэм, нийгмийн бүлгийн олонх гишүүдийн хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хүлээлттэй үл нийцэх төлвийг хэлнэ.
- E. Нийгэм, нийгмийн бүлгийн олонх гишүүдийн хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хүлээлттэй нийцэх төлвийг хэлнэ.

16. Төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм соёлын байгууллагыг удирдах, төрийн гадаад бодлогыг хэрэгжүүлэх зэрэг үүрэг гүйцэтгэх байгууллага аль нь вэ? /2 оноо/

- A. Улсын Их Хурал
- B. Засгийн газар
- C. Ерөнхийлөгч
- D. Шүүх
- E. ИНБ

17. “Олон улсын харилцааны тоглогчид нь зөвхөн үндэсний бүрэн эрхт улсууд байдаг” гэж үздэг онолыг нэрлэнэ үү. /2 оноо/

- A. Неолиберал онол
- B. Неореалист онол
- C. Либерал онол
- D. Реалист онол
- E. Марксист онол

18. Олон улсын харилцааны хатуу хүчний бодлогын үйлдлийн төрлийг сонгоно уу. /1 оноо/

- A. Захирах чадвар
- B. Урамшуулал
- C. Удирдамж
- D. Үнэмшил
- E. Цэргийн хүч

19. Эцэг эх, гэр бүлээс залгамжилсан төрөлхийн байр суурьтай нь тодорхой хувь хүний олдмол байр суурийг харьцуулахад өөрчлөлт гарсан бол аль шилжих хөдөлгөөнд харьяалагдах вэ?

- A. Босоо шилжих хөдөлгөөн
- B. Хувийн шилжих хөдөлгөөн
- C. Үе хоорондын шилжих хөдөлгөөн
- D. Үе дотоодын шилжих хөдөлгөөн
- E. Хэвтээ шилжих хөдөлгөөн

20. Монголын социализмын үеийн нийгмийн давхраажилтын ангиллыг ялгаатай бүтэцтэй нь тохируулна уу. /2 оноо/

A	Ажилчдын	1	Босоо шатлалын дагуу эрх мэдэл, орлогын ялгаатай
B	Сэхээтний	2	Тээврийн, үйлчилгээний, аж үйлдвэрийн салбартай
C	Номенклатура	3	Нийтийн ба хоршооллын өмчлөлөөрөө ялгаатай

A. a2, b1, c3


B. a1, b2, c3

C. a3, b1, c2

D. a3, b2, c1

E. a2, b3, c1

21. Дараах бүдүүвчийг ажиглаад соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд баримтлах зарчмуудыг гүйцээгээрэй. /2 оноо/



- A. Иргэдийн авьяасыг нээн, хөгжүүлэх, таниулах боломжийг бий болгоно
- B. Улс орнуудыг соёл, ёс заншлаар нь ялган таниулах гол арга зам болгох
- C. Орон нутгийн хүн амын амжиргаа, нийгэм, эдийн засгийн хөгжилд үр ашгаа өгөх
- D. Тухайн соёлын бусдаас ялгарах, дахин давтагдашгүй шинжийг нээх
- E. Иргэдийн оролцоо нь нийгмийг нягтруулж, бүлгийг хүчирхэг болгох

22. “Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрийг соёлын үйлдвэрлэл үйлчилгээ явуулах боломж, нийгэм, эдийн засгийн үр ашгийг харгалзан үзэж тодорхой хүрээнд хэрэгжүүлэхээр заасан байдаг. Үүнд хамаарах хүрээг ялгана уу. /2 оноо/

- |                  |                            |                       |
|------------------|----------------------------|-----------------------|
| 1. Кино урлаг    | 2. Уламжлалт анагаах ухаан |                       |
| 3. Шинжлэх ухаан | 4. Техник технологи        | 5. Тайзны уран бүтээл |

- A. 2, 4
- B. 4, 5
- C. 2, 3
- D. 1, 5
- E. 3, 4

23. 2023 онд Монгол улсын экспорт нь 490 тэрбум төгрөг, импорт нь 330 тэрбум төгрөг байсан бол тус оны МУ-ын гадаад худалдааны тэнцлийг тооцоолно уу. /2 оноо/

- A. 820
- B. -160
- C. 160
- D. - 820
- E. 410

24. Хөдөлмөрийн зах зээлд цалингийн түвшин 600 мянган төгрөг болж өсөхөд хөдөлмөрийн нийлүүлэлт 500 нэгж байсан. Тэгвэл хөдөлмөрийн эрэлт 100 нэгж байхад ямар үзэгдэл бий болох вэ? /2 оноо/

- A. Ажилах хүчний хомсдол бий болно (400 нэгжээр буурсан)
- B. Ажиллах хүчний илүүдэл бий болно (200 нэгжээр өссөн)
- C. Ажиллах хүчний хомсдол бий болно (200 нэгжээр буурсан)
- D. Ажиллах хүчний илүүдэл бий болно (400 нэгжээр өссөн)
- E. Ажиллах хүч илүүдэл бий болно (600 нэгжээр өссөн)

25. Дараах өгөгдлөөс иргэний улс төр дэх хууль ёсны оролцоог ялгана уу. /2 оноо/

- |                                  |   |
|----------------------------------|---|
| 1. Сонгуульд санал өгөх          | 2. Улс төрийн шийдвэрийг дагахаас татгалзах |
| 3. Эсэргүүцлийн жагсаалд оролцох | 4. Нийгэм, улс төрийн амьдралд оролцох      |

- A. 1, 3
- B. 1, 2
- C. 2, 4
- D. 2, 3
- E. 1, 4



### ХОЁРДУГААР ХЭСЭГ /40 оноотой/

**Санамж:** Даалгавар бүрийг анхааралтай уншиж гүйцэтгэнэ үү. Ойлголт тус бүр 1 оноо

31. Нийгэм, нийгмийн харилцааны дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

1	Нийгмийн ялгарал	A	Ижил төстэй шинж бүхий хүн амын статистик нэгдэл
2	Тэгш бус байдал	B	Тодорхой хэв шинжит харилцаа бүхий тэгш бус байдлын тогтолцоо
3	Нийгмийн давхраажилт	C	Нийгмийн гишүүд хувийн болон нийгмийн шинжээрээ зааглагдан хуваагдахыг хэлнэ.
4	Нийгмийн нийтлэг	D	Эдийн засгийн баялаг, нэр хүнд, эрх мэдэлд хүрэх адил бус боломж бүхий байдлыг хэлнэ.

32. Соёлын дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

1	Соёлын даяаршил	A	Соёлын үнэлэмжүүдийн харилцан нөлөөллөөр бий болж байдаг орчин.
2	Соёлын орон зай	B	Соёл өөрийн үнэт зүйлсээ хамгаалж, оршин тогтнолоо бэхжүүлэн баталгаажуулах чадвар.
3	Соёлын адилсал	C	Ард түмэн өөрийн соёлын хэм хэмжээ, зан үйл, хэл, үнэлэмжийн баримжааллыг ухаарч ойлгох чадвар.
4	Соёлын дархлаа	D	Зам харилцаа, эдийн засаг, мэдээлэл харилцааны хөгжлийн үндсэн дээр тусгаар соёлууд дэлхийн нэгдмэл соёлд нэгдэн нийлэх үйл явц.

33. Эдийн засгийн дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

1	Татвар	A	Тодорхой хэмжээний мөнгийг тогтоосон хугацааны дараа, зохих хүүтэй эргүүлэн төлөхийн баталгаа болох үнэт цаас
2	Бонд	B	Нийт эргэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөл бодлого
3	Төсвийн бодлого	C	Нийт эргэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөх бодлого
4	Төрийн мөнгө, зээлийн бодлого	D	Хуулийн дагуу тогтоосон хэмжээгээр бүх хүн, хуулийн этгээдээс төрд заавал төлөх, буцалтгүй шинжтэй хураамж

34. Эдийн засгийн дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

1	Олон улсын худалдаа	A	Экспорт, импортын зөрүү
2	Гадаад худалдааны тэнцэл	B	Улс орнуудын хооронд бараа, үйлчилгээ шилжих хөдөлгөөн
3	Нийт эргэлт	C	Экспорт, импортын нийлбэр
4	Дэлхийн зах зээл	D	Улс орнуудын хооронд бүтээгдэхүүн солилцох явц

35. Улс төр

Сонирхлын бүлгийн хэв шинжийг зөв харгалзуулна уу.

1	Аномик	A	Цэрэг зэвсэглэл, арми, сүм хийд зэрэг субъектийн шууд удирдлаган дор зохион байгуулалттай үүсгэн байгуулдаг бүлэг
2	Эвсэл холбооны	B	Тодорхой зохион байгуулалтгүй хэсэг бөөн хүмүүсийн цугларалт, бослого, үймээн
3	Эвсэл холбооны бус	C	Өөрийн гэсэн тодорхой зорилго, чиглэлд үндэслэгдсэн зохион байгуулттай бүлэг
4	Байгуулагдажсан	D	Хүмүүс голдуу яс үндэс, угсаа гарвал, арьс өнгө, шашин шүтлэг, нас, хүйс зэрэг нийтлэгээрээ ялгардаг бүлэг

36. Улс төр

*Сонгуулийн тогтолцоог зөв харгалзуулна уу.*

1	Пропорциональ тогтолцоо	A	Хамгийн олон санал авсан нэр дэвшигч ялсанд тооцогдоно.
2	Энгийн олонх	B	50-аас дээш хувийн санал авсан нэр дэвшигч ялсанд тооцогдоно.
3	Харьцангуй олонх	C	Нийт саналын $\frac{3}{4}$ эсвэл $\frac{2}{3}$ хувиас дээш санал авсан нэр дэвшигч ялсанд тооцогдоно.
4	Үнэмлэхүй олонх	D	Намын нэрээр санал хурааж авсан саналд нь хувь тэнцүүлж суудал хуваарилдаг.

37. Эрх зүй

*Төр, хүний эрхийн талаарх дараах сэтгэгчдийн байр суурийг зөв харгалзуулна уу.*

1	Т.Гоббс	A	Төр бол “татвараар сорон мөлжигч”
2	Ф.Бастиа	B	Төр бол “зайлшгүй байх ёстой муу зүйл”
3	Р.Нозик	C	Төр бол “левиафан”
4	Ж.С.Милл	D	Төр бол “хүний эрхийн гол дайсан”

38. Эрх зүй

*Өмчлөх эрхийн талаарх дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу.*

1	Өмчлөх эрх	A	Тухайн баялгийн үр шимийг хүртэх
2	Ашиглах эрх	B	Тухайн баялгийг бүрэн хараа хяналтдаа байлгах
3	Эзэмших эрх	C	Тус баялгийг худалдах, бэлэглэх, арилжих, зээлэх зэргийг шийдвэрлэх боломж
4	Зарцуулах эрх	D	Эдийн болон эдийн бус баялгийг ашиглах, эзэмших, захиран зарцуулах боломж

39. Олон улсын харилцаа

*Олон улсын харилцааны улс бус оролцогчдыг зөв харгалзуулна уу.*

1	Үндэстэн дамнасан корпорац	A	Coca cola, Toyota
2	Хувь хүн	B	BBC, CNN
3	Гэм хэргийн сүлжээ байгууллага	C	Далай лам, Ромын пап
4	Олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэл	D	Зэвсгийн наймаа, хар тамхи

40. Олон улсын харилцаа

*Монгол улсын түншлэлийн харилцаатай улсуудыг зөв харгалзуулна уу.*

1	Иж бүрэн стратегийн түншлэл	A	ОХУ, Япон, Энэтхэг
2	Стратегийн түншлэл	B	БНСУ, АНУ, Герман, Турк
3	Иж бүрэн түншлэл	C	Канад, Австрали
4	Өргөн хүрээтэй түншлэл	D	БНХАУ



**ХАЛХГОЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
11-Р АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

**В хувилбар**

*Асуулт даалгавар бүрийг анхааралтай уншиж, зөв хариултыг хариултын хуудсанд тэмдэглэнэ үү.*

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ /60 оноотой/**

- Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой.  
..... гэдэг нь ижил төстэй шинж бүхий хүм амын статистик нэгдэл. /2 оноо/  
A. Нийгмийн давхраажилт                      B. Нийгмийн ялгарал  
C. Нийгмийн давхраа                            D. Тэгш бус байдал                            E. Нийгмийн нийтлэг
- Монгол Улс хэдэн онд дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрт нэгдэн орсон бэ? /2 оноо/  
A. 1970 он                      B. 1980 он                      C. 1990 он                      D. 2000 он                      E. 2005
- Тодорхой хэмжээний мөнгийг тогтсон хугацааны дараа, зохих хүүтэй эргүүлэн төлөхийн баталгаа болох үнэт цаасыг юу гэж нэрлэдэг вэ? /2 оноо/  
A. Хураамж                      B. Татвар                      C. Бонд                            D. Татаас                            E. Хувьцаа
- Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /2 оноо/  
..... бол улс орны хөгжлийн бодлогыг хамтын зарчмаар тодорхойлж, хэрэгжүүлж, улс төрийн хамтын хариуцлага хүлээх чадвартай иргэдийн эвлэлдэн нэгдсэн байгууллага юм.  
A. Лобби бүлэг                                      B. Улс төрийн нам  
C. Иргэний нийгэм                                      D. Сонирхлын бүлэг                                      E. Улс төрийн институт
- Ерөнхийлөч эрх зүйн ямар акт гаргадаг вэ? /2 оноо/  
A. Тушаал                                      B. Захирамж  
C. Шийдвэр                                      D. Тогтоол                                      E. Зарлиг
- Монгол улсын Иргэний хуулийг хэдэн онд баталсан бэ? /2 оноо/  
A. 1948 он                                      B. 1966 он                                      C. 1996 он                                      D. 2000 он                                      E. 2002 он
- Засгийн газрын оролцоо дэмжлэггүйгээр улс, үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулдаг глобал түвшний оролцогчид, тоглогчид, олон улсын байгууллагыг юу гэж нэрлэдэг вэ? /2 оноо/  
A. Олон улсын харилцаа  
B. Улс бус оролцогч  
C. Олон улсын эрх зүй  
D. Гуравдагч хөршийн бодлого  
E. Түншлэлийн харилцаа



8. Олон улсын байгууллагын үйл ажиллагааны глобал түвшинд аль нь хамаарах вэ? /2 оноо/

- A. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн
- B. Ази Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны чуулга
- C. Аль Кайда бүлэглэл
- D. Евразийн эдийн засгийн холбоо
- E. Walmart

9. Дараах бодомжуудаас марксизм (шүүмжлэлт онол) онолыг нийгмийн судалгааны үүднээс тайлбарласныг олоорой. /2 оноо/

- A. Нийгэм нь хувь хүний хүсэл зоригоос үл хамаарах объектив мөн чанартай тул нийгмийн судалгаагаар нийгмийн бодит байдал дахь үзэгдэл хоорондын зүй тогтлыг илрүүлж чадна.
- B. Нийгмийн бодит байдлыг судлах нь хүмүүс хэрхэн харилцдаг, тэдгээр хүмүүсийн үйлдэлд илрэх утга учрыг тэдний нүдээр харж, ойлгох явдал гэж үзнэ.
- C. Эрх мэдэлтэй хийгээд эрх мэдэл багатай хүмүүсийн харилцааны цаана оршин буй нийгмийн бодит байдлыг илрүүлэн өөрчлөх, сайжруулах боломжийг хайхаар нийгмийн судалгааг хийдэг гэж үздэг.
- D. Мэдлэгийг бүтээхдээ байгаль судлаачдын адилаар дедукцийн аргын дагуу объективоор судлан онол бүтээх боломжтой гэж үздэг.
- E. Нийгмийн тухай ерөнхий онол гэж байх боломжгүй бөгөөд судлагдсан бодит байдлаар индукцийн аргын дагуу тодорхой түвшний онол бүтээх боломжтой гэж үздэг.

10. “Хүнийг өдөр бүр телевизийн дэлгэц болон дэлхийн цахим сүлжээний шүүлтүүр муутай мэдээллээр угжаад байвал хүний, түүний эргэн тойрныхны мэдлэг туршлага, үнэт зүйл алдагдах нь илэрхий” гэсэн мэдээлэл нь дараах ойлголтоос алийг түлхүү илэрхийлж байна вэ? /2 оноо/

- A. Соёлын дархлаа сулрах шалтгаан
- B. Соёлоо хадгалж үлдэх шалтгаан
- C. Соёлоо эрхэмлэхийн шалтгаан
- D. Соёлын суурь зарчмын шалтгаан
- E. Соёлын зөрчих хандлагын шалтгаан

11. Эдийн засгийн амьдрал, логик, ёс зүй болон социализмын шинжлэх ухааны үндэслэлийг бүх талаас нь авч үзсэн ч маш алдаатай байсан гэдгийг хэн нотолсон бэ? /2 оноо/

- A. А. Смит
- B. Ф. Хайек
- C. М. Кейнс
- D. Д. Рикорда
- E. Р.Дарендорьф

12. Дараах эдийн засгийн ойлголтоос аль нь Д.Кейнсийн үзэл баримтлал вэ? /2 оноо/

- A. Эдийн засаг дахь төрийн идэвхтэй оролцоо нь түүнд зөвхөн хор учруулна.
- B. Гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ болон үнийн түвшин нь шууд хамааралгүй.
- C. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг шинжлэх ухааны үндэслэлтэй судалсан.
- D. Эдийн засагт төрийн оролцоо нь нийт эрэлтийг нэмэгдүүлэх гол арга зам гэж үзсэн.
- E. Эдийн засгийн салбарт оруулсан хувь нэмрийг үнэлэн Нобелийн шагнал олгосон.

13. Улс төр судлаач Г.Алмондын тодорхойлсон улс төрийн системийн оролтын чиг үүрэгт хамаарах өгөгдлийг олно уу. /2 оноо/

- A. Хууль зүйн хэм хэмжээ, шийдвэр боловсруулах
- B. Хэм хэмжээ шийдвэрийг хэрэгжүүлэх
- C. Улс төрийн нийгэмшилтийг хангах
- D. Хэм хэмжээг хэрхэн дагаж мөрдөж буйг хянах
- E. Улс төрийн нам сонгуулиар дамжин төрийн эрх барих

14. Дараах өгөгдлөөс намын нийгэмд гүйцэтгэх үүргийг ялгаарай. /2 оноо/

- 1. Улс орны хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх
- 2. Засгийн эрхийг авахын төлөө өрсөлдөх
- 3. Төрийн санхүүжилтыг багасгах, хасах
- 4. Бодлогын хэрэгжилтийг тайлагнах, хариуцлага хүлээх

A. 1,3                      B. 1, 4                      C. 2,4                      D. 1, 2                      E. 2, 3

15. Гэмт хэргийн бус зөрчилд хамаарах ойлголт аль нь вэ? /1 оноо/

- A. Нийгэмд хор аюултай, хууль зүйн хариуцлага хүлээлгэх шаардлагатай, гэм буруутай үйлдэл, эс үйлдлийг хэлнэ
- B. Нийгэмд хор аюултай, хууль зүйн хариуцлага хүлээлгэх шаардлагатай, эрүүгийн хуульд заасан гэм буруутай бүх үйлдэл, эс үйлдлийг хэлнэ
- C. Нийгэм, нийгмийн бүлгийн олонх гишүүдийн хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хүлээлттэй үл нийцэх төлвийг хэлнэ.
- D. Нийгмийн хуульчлан тогтоосон хэм хэмжээг ноцтойгоор зөрчиж бусдад гэм хор, хор хохирол учруулсан үйлдэл, эс үйлдэл хамаарна.
- E. Захиргааны, эд хөрөнгийн, сахилгын зөрчил гаргасан гэм буруутай бүх үйлдэл, эс үйлдэл хамаарна.

16. Үндсэн хуулийн цэц эрх зүйн ямар акт гаргадаг вэ? /2 оноо/

- A. Шийдвэр                      B. Захирамж                      C. Тушаал                      D. Тогтоол                      E. Зарлиг

17. Олон улсын харилцааны тоглогчид нь бүрэн эрхт улс, тэдгээрийн холбоо эвсэл байна гэж үздэг онолыг нэрлэнэ үү. /2 оноо/

- A. Либерал онол    B. Реалист онол
- C. Неореалист онол    D. Неолиберал онол    E. Марксист онол

18. Зөөлөн хүчний бодлогын үйлдлийн төрлийг сонгоно уу. /2 оноо/

- A. Үнэт зүйлс, төрийн бодлого    B. Эдийн засгийн хүч
- C. Захирах чадвар    D. Удирдамж    E. Сэтгэл татам байдал

19. Эцэг эх, гэр бүлээс залгамжилсан төрөлхийн байр суурьтай нь тодорхой хувь хүний олдмол байр суурьтай харьцуулалгүйгээр өөрчлөлт гарсан бол аль шилжих хөдөлгөөнд харьяалагдах вэ? /2 оноо/


- A. Босоо шилжих хөдөлгөөн
- B. Хувийн шилжих хөдөлгөөн
- C. Үе хоорондын шилжих хөдөлгөөн
- D. Үе дотоодын шилжих хөдөлгөөн
- E. Хэвтээ шилжих хөдөлгөөн

20. Манжийн эрхшээлийн үеийн монголын нийгмийн давхраажилтыг хамаарах бүтэцтэй нь тохируулна уу. /2 оноо/

A	Дээд давхраа	1	Засаг ноёдоос хамгийн олон нь алтан ургийн ноёд байсан.
B	Дунд давхраа	2	Өмч хөрөнгө, эрх мэдэлгүй гэрийн боолууд
C	Доод давхраа	3	Ноёдод татвар нийлүүлж, мал сүргийг нь адгуулах үүрэгтэй.

A. a1, b2, c3 B. a1, b3, c2 C. a3, b1, c2 D. a3, b2, c1 E. a2, b1, c3

21. Дараах бүдүүвчийг ажиглаад соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд баримтлах зарчмуудыг гүйцээгээрэй. /2 оноо/



- A. Тухайн соёлын бусдаас ялгарах, дахин давтагдашгүй өвөрмөц шинжийг нээх
- B. Эрх чөлөө, ардчилал, хүлээцтэй байдал, шударга ёсны үнэ цэнийг дэлгэрүүлэх
- C. Дэлхийд өөрсдийн брэндийг бий болгож, шударга өрсөлдөөнийг дэмжих
- D. Байгалийн болон соёлын өвийн газруудтай харилцан шүтэлцээтэй хөгжүүлэх
- E. ДНБ-ийн хэмжээг нэмэгдүүлэн ард түмний амьжиргааг дээшлүүлэх

22. Соёлын үйлдвэрлэл үндэсний хөтөлбөрийг соёлын үйлдвэрлэл үйлчилгээ явуулах боломж, нийгэм, эдийн засгийн үр ашгийг харгалзан үзэж тодорхой хүрээнд хэрэгжүүлэхээр заасан байдаг. Үүнд хамаарах хүрээг ялгана уу. /2 оноо/

- |                          |                        |                  |
|--------------------------|------------------------|------------------|
| 1. Дизайн, дүрслэх урлаг | 2. Дэвшилтэд технологи | 3. Шинжлэх ухаан |
| 4. Соёлын аялал жуулчлал | 5. Соёлын шок          |                  |

A. 4, 5 B. 1, 4 C. 2, 3 D. 2, 4 E. 3, 4

23. 2023 онд Монгол улсын экспорт нь 490 тэрбум төгрөг, импорт нь 330 тэрбум төгрөг байсан бол тус оны МУ-ын гадаад худалдааны нийт эргэлтийг тооцоолно уу. /1 оноо/

A. 820 B. -160 C. 160 D. - 820 E. 410

24. Хөдөлмөрийн зах зээлд цалингийн түвшин 300 мянган төгрөг болж өсөхөд хөдөлмөрийн нийлүүлэлт 200 нэгж байсан. Тэгвэл хөдөлмөрийн эрэлт 400 нэгж байхад ямар үзэгдэл бий болох вэ? /2 оноо/

- A. Ажиллах хүчний илүүдэл бий болно (200 нэгжээр өснө)
- B. Ажиллах хүчний хомсдол бий болно (200 нэгжээр буурсан)
- C. Ажиллах хүчний хомсдол бий болно (300 нэгжээр буурсан)
- D. Ажиллах хүчний илүүдэл бий болно (300 нэгжээр өснө)
- E. Ажиллах хүчний илүүдэл бий болно (600 нэгжээр өссөн)

25. Дараах өгөгдлөөс иргэний улс төр дэх хууль ёсны бус оролцоог ялгана уу. /2 оноо/

- |                                  |   |
|----------------------------------|---|
| 1. Сонгуульд санал өгөх          | 2. Улс төрийн шийдвэрийг дагахаас татгалзах |
| 3. Эсэргүүцлийн жагсаалд оролцох | 4. Нийгэм, улс төрийн амьдралд оролцох      |

- A. 2, 3                      B. 1, 2                      C. 2, 4                      D. 1, 4                      E. 1, 3

26. Сонгуулийн тогтолцоог тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /2 оноо/

A	Мажоритари тогтолцоо	1	Мажоритари болон пропорциональ тогтолцооны аль алиных нь онцлог шинжийг хадгалсан тогтолцоо
B	Пропорциональ тогтолцоо	2	Өрсөлдөгчөөсөө илүү санал авсан нь ялдаг тогтолцоо
C	Холимог тогтолцоо	3	Намын нэрээр санал хурааж авсан саналд нь хувь тэнцүүлж суудал хуваарилдаг тогтолцоо

- A. a1,b2,c3                      B. a2,b1,c3                      C. a1,b3,c2                      D. a2,b3,c1                      E. a3,b1,c2

27. Хүснэгт дэх өмчлөх эрхтэй холбоотой ойлголтуудыг ажиглаад 1, 2 хэсгийг харьцуулаад, аль хэсгийн, ямар дараалалд алдаа байгааг тодорхойлоорой. /2 оноо/

Хэсэг	А. Өмчлөх эрх үүсэх үндэслэл	Б. Өмчлөх эрхээ хэрхэн хамгаалах вэ?	В. Өмчлөх эрхийн эсрэг чиглэсэн үйлдэл
1-р хэсэг	Эд хөрөнгийг дайчлан авах нь хуульд заасан үндэслэл болно.	Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргана.	Мал хулгайлах, дээрэмдэх
2-р хэсэг	Шүүхийн шийдвэрийн дагуу эд хөрөнгөтэй болох нь гэрээнд заасан үндэслэл болно.	Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргана.	Хөрөнгө завших, бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх

- A. 2-р хэсгийн Б                      B. 1-р хэсгийн В  
C. 1-р хэсгийн А                      D. 2-р хэсгийн А                      E. 2-р хэсгийн В

28. Гэмт хэргийн бус зөрчилд хамаарах ойлголт аль нь вэ? /2 оноо/

- A. Нийгэмд хор аюултай, хууль зүйн хариуцлага хүлээлгэх шаардлагатай, гэм буруутай үйлдэл, эс үйлдлийг хэлнэ  
B. Нийгэмд хор аюултай, хууль зүйн хариуцлага хүлээлгэх шаардлагатай, эрүүгийн хуульд заасан гэм буруутай бүх үйлдэл, эс үйлдлийг хэлнэ  
C. Нийгэм, нийгмийн бүлгийн олонх гишүүдийн хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хүлээлттэй үл нийцэх төлвийг хэлнэ.  
D. Нийгмийн хуульчлан тогтоосон хэм хэмжээг ноцтойгоор зөрчиж бусдад гэм хор, хор хохирол учруулсан үйлдэл, эс үйлдэл хамаарна.  
E. Захиргааны, эд хөрөнгийн, сахилгын зөрчил гаргасан гэм буруутай бүх үйлдэл, эс үйлдэл хамаарна.

29. Гуравдагч хөрш орнуудтай дипломат харилцаа тогтоосон оныг буурах эрэмбэд оруулна уу. /2 оноо/

- |         |         |         |        |
|---------|---------|---------|--------|
| 1. БНСУ | 2. Япон | 3. Турк | 4. АНУ |
|---------|---------|---------|--------|

- A. 1, 4, 2, 3                      B. 1, 4, 3, 2                      C. 4, 1, 2, 3                      D. 2, 3, 1, 4                      E. 4, 3, 1, 2

30. Жозеф Самуэль Най, Роберт Коэхэнтэй хамтран 1977 онд олон улсын харилцааны неолиберал онолын чиглэлээр “хүч чадавх ба харилцан хамаарал” гэсэн бүтээлээ туурвисан. Энэхүү бүтээлд хамаарах үзэл санааг ялгаарай. /2 оноо/

1. Клинтоны засаглалын үед түүний ухаалаг хүчний бодлогыг дэмжсэн
2. ОХУ-д зөөлөн хүчний бодлогыг дэвшүүлж, хүлээн зөвшөөрүүлсэн
3. Эдийн засгийн дипломат харилцааг тодорхойлж тайлбарласан
4. Гадаад худалдааны протекционист бодлогыг дэвшүүлсэн

A. 1, 2

B. 1, 3

C. 2, 4

D. 3, 4

E. 2, 3

### ХОЁРДУГААР ХЭСЭГ /40 оноотой/

**Санамж:** Даалгавар бүрийг анхааралтай уншиж гүйцэтгэнэ үү. Ойлголт тус бүр 1 оноо

31. Нийгэм, нийгмийн харилцаа

Нийгмийн өөрчлөлтийн талаарх дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

1	Ан агнуурын нийгэм	A	Энгийн хөдөлмөрийн багаж зэвсэг ашиглан тариалангийн аж ахуй эрхэлдэг ч, нэмүү өртөг бүтээх түвшинд хүрээгүй ураг төрлийн холбоонд суурилсан нийгэм
2	Цэцэрлэг аж ахуйн нийгэм	B	Ураг төрлийн холбоонд тулгуурлахаа больж, төр үүсэж, бичиг үсэг хэрэглэх болж, мөнгөн гүйлгээ ашиглах болжээ.
3	Газар тариалангийн нийгэм	C	Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг асар их хэмжээгээр үйлдвэрлэж, төвлөрөн суурьшсан хотын маш олон хүн амын хэрэгцээг хангах болсон.
4	Аж үйлдвэржсэн нийгэм	D	Чулуун сүх, жад, хутга зэрэг энгийн зэвсэг ашигладаг, улс төрийн бүтэцгүй, овгийн байгуулал бүхий нийгэм

32. Соёлын дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

1	Соёлын цочирдол	A	Компьютер, технологи, цахим сүлжээнд суурилсан соёлын харилцаа, нөлөөллөөр бий болж буй хамтын мэдрэмж
2	Соёлын эрх чөлөө	B	Хувь хүний бүтээлч сэтгэлгээ, ур чадвар, авьяас билгээс эх сурвалжтай, оюуны өмчөөр хамгаалагдсан соёлын агуулга бүхий бараа, бүтээл үйлдвэрлэх
3	Кибер орон зай	C	Бүх хүмүүс эх хэлээрээ ярьж, өөрийн шашныг шүтэж, өөрийн соёлыг бүтээн туурвих бололцоо
4	Соёлын үйлдвэрлэл	D	Өөр соёлын орчин нөхцөл тухайн хүний хүссэнээс огт өөр байх, бүтэлгүйтэх, сэтгэл ханамж мэдрэгдэхгүй байх

33. Эдийн засгийн дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

1	Экспорт	A	Үйлдвэрлэгчид гадаадын зах зээлд нэвтрэхийн тулд өрсөлдөгчөөсөө доогуур үнээр бараагаа шахаж дараа нь үнээ өсгөх зорилготой түр зуурын үзэгдэл
2	Импорт	B	Бусад орнуудаас бараа, үйлчилгээг худалдан авах
3	Демпинг	C	Гадаад орнуудад бараа, үйлчилгээг гаргах
4	Протекционизм	D	Аж үйлдвэр нь өрсөлдөх чадвараар сул, хөгжиж байгаа улс орнууд гадаад худалдааны хамгаалах бодлого

34. Төрийн эдийн засгийн дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

1	Хүүгийн бодлого	A	Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх бодлого
2	Мөнгө, зээлийн бодлого	B	Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөх бодлого
3	Сангийн төсвийн бодлого	C	Хуулийн дагуу, тогтоосон хэмжээгээр бүх хүн, хуулийн этгээдээс төрд заавал төлөх, буцалтгүй шинжтэй хураамж
4	Татварын бодлого	D	Хүү буурахад иргэд болон ААН-үүдээс хэрэглээ болон хөрөнгө оруултдаа зориулж авах зээлийн хэмжээ нэмэгдэнэ.

35. Улс төр Иргэний нийгмийг төлөвшүүлэх төрийн бодлогын хүрээг зөв харгалзуулна уу.

1	Эдийн засгийн хүрээнд	A	Эрх мэдлийг зохистой тэнцвэржүүлэн хуваарилсан байх
2	Нийгмийн хүрээнд	B	Арьс өнгө, нас хүйс, үндэс угсаа, нийгмийн байдлаар нь ялгаварлахгүйгээр хүний эрх, эрх чөлөөг дээдлэх
3	Оюун санааны хүрээнд	C	Өмчийн олон хэлбэр эрх тэгш хөгжиж, хүмүүс хувийн өмчтэй байх
4	Улс төрийн хүрээнд	D	Нийгмийн гишүүд үг хэлэх, хэвлэн нийтлэх, аливаа нэг улс төрийн байгууллагаас хараат бус байх

36. Улс төр Сонгуулийн талаарх дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

1	Сонгууль	A	Хорих ял эдэлж байгаа, эрх зүйн чадамжгүй нь шүүхээр тогтоогдсон бол сонгох эрхгүй.
2	Сонгох эрх	B	Хоёр ба түүнээс дээш тооны нэр дэвшигч, улс төрийн нам, эвслээс иргэн хүн тэгш эрхтэйгээр сонголтоо өөрийн биеэр, чөлөөтэй хийж, үр дүн нь шууд гарах улс төрийн сонголт
3	Сонгогдох эрх	C	Иргэний төрийн байгууллагын бүрэлдэхүүнд сонгогдох
4	Сонгох эрхийн шалгуур	D	Хоёр ба түүнээс дээш нэр дэвшигч эсвэл улс төрийн намаас сонголт хийх

37. Эрх зүй

Гэм хорыг арилгах арга замыг зөв харгалзуулна уу.

1	Эд хөрөнгөд	A	Уучлалт гуйхыг шаардах
2	Сэтгэл санаанд	B	Хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого нэхэмжлэх
3	Эрүүл мэндэд	C	Мөнгөөр нөхөн төлөхийг шаардах
4	Амь насанд	D	Оршуулгын зардал төлүүлэх

38. Эрх зүй

Төрийн хүний эрхийг хамгаалах чиг үүргийг зөв харгалзуулна уу.

1	Хууль тогтоох	A	Төрийн бус байгууллага
2	Гүйцэтгэх эрх мэдэл	B	Шүүх
3	Шүүх эрх мэдэл	C	Засгийн газар
4	ИНБ	D	Улсын их хурал

39. Олон улсын харилцааны улс бус оролцогчдыг зөв харгалзуулна уу.

1	Үндэстэн дамнасан корпорац	A	Рио тинто, Эрдэнэт үйлдвэр
2	Хувь хүн	B	Билл Гейтс, У.Хүрэлсүх
3	Гэм хэргийн сүлжээ байгууллага	C	Санхүү, технологийн хулгай
4	Олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэл	D	Фейсбүүк, твитер

40. Олон улсын харилцаа Монгол улсын гуравдагч хөрш орнуудтай элчин сайдын яам нээсэн оныг зөв харгалзуулна уу.

1	Япон	A	1997 он
2	Америк	B	1991 он
3	БНСУ	C	1973 он
4	Турк	D	1988 он

**ХАЛХГОЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
11-Р АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ТҮЛХҮҮР**

<b>№</b>	<b>А хувилбар</b>	<b>В хувилбар</b>
1	B	E
2	A	E
3	B	C
4	C	C
5	B	E
6	B	E
7	B	B
8	D	D
9	C	C
10	D	A
11	C	B
12	B	A
13	A	A
14	A	B
15	B	E
16	B	A
17	D	C
18	C	E
19	C	D
20	E	B
21	C	D
22	D	B
23	A	A
24	D	B
25	E	A
26	D	D
27	B	D
28	B	E
29	E	A
30	B	A
31	1C,2D,3B,4A	1D 2A 3B 4C
32	1D,2A,3C,4B	1D 2C 3A 4B
33	1D,2A,3B,4C	1C 2B 3A 4D
34	1B,2A,3C,4D	1D 2B 3A 4C
35	1B,2C,3D,4A	1C 2B 3D 4A
36	1D,2B,3A,4C	1B 2D 3C 4A
37	1C,2A,3D,4B	1C 2A 3B 4D
38	1D,2A,3B,4C	1D 2C 3B 4A
39	1A,2C,3D,4B	1A 2B 3C 4D
40	1D,2A,3B,4C	1c 2D 3B 4A